



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IY байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013-03-11 № 01/13 - УАГ-САГ/2013/13  
СТГА-ТМЗ

Түрээсийн орлого төвлөрүүлэх тухай

Монгол цэргийн музей нь “Хулдугар хун” ХХК, “Даниста бейкери” ХХК, “Грийт колумн” ХХК, “Номт пресс” ХХК-тай байгуулсан ажлын байр түрээслэх гэрээний дагуу 2012 онд нийт 3467,5 мянган төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлжээ.

Төрийн өмчийн хорооны 2007 оны 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.8-д “Түрээслүүлэгч нь түрээслэгчээс авсан түрээсийн төлбөрийн нийт үнийн дүнгийн 20 хувийг Төрийн өмчийн хорооны Төрийн сан дахь дансанд сар бүр төвлөрүүлнэ” гэсэн заалтыг зөрчиж нийт үнийн дүнгийн 20 хувь болох 693,5 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-ын “Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

Түрээсийн орлогын 20 хувь болох 693,5 мянган төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь улсын төсвийн 900000601 дугаар дансанд 2013 оны 3 дугаар сарын 31-ний дотор нөхөн төлөхийг Монгол цэргийн музейн дарга Г.Золзаяа, ерөнхий нягтлан бодогч Л.Ганхуяг нарт хариуцуулан төлбөрийн акт тогтоов.

**ТОГТООСОН:**  
УАГ-ын ахлах аудитор  
Д.Ганбилэг  
УХА0122  
Дундманхайдай аудитын  
компаний аудитор

3.Цээнээ

**АКТЫГ**

**ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:**

Монгол цэргийн музейн дарга  
Г.Золзаяа

Ерөнхий нягтлан бодогч  
Л.Ганхуяг

Л.Ганхуяг